



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 8/192

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны
“Уясах” ӨЭМТ-ийн данс бүртгэлээс
тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/172 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн харилцааны газраас 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсан 6,210,000.0 /зургаан сая хоёр зуун арван мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Хьюндай Аксент маркийн 51-41 УБЕ улсын дугаартай тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны “Уясах” өрхийн эрүүл мэндийн төв /Г.Батчимэг/-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны “Уясах” ӨЭМТ /Г.Батчимэг/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ